



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/190

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэнийн нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн “Зөвлөлийн бүрэлдэхүүн, журам шинэчлэн батлах тухай” А/163 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан “Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх зөвшөөрөл олгох журам”-ын 5.1.1 дэх заалтад “Олон улсын болон орон нутгийн хөөрөлт, буултын батлагдсан нислэгийн цагийн хуваарьт зөвхөн цаг агаарын болон агаарын хөлгийн техникийн шалтгаанаар өөрчлөлт оруулах бөгөөд бусад шалтгаанаар өөрчлөлт оруулах тохиолдолд нислэгийн хүсэлтийг Цагийн хуваарийн зөвлөлд хүргүүлнэ.” гэснийг “Олон улсын болон орон нутгийн батлагдсан хуваарьт хөөрөлт, буултын нислэгийн цагийн хуваарьт 5 буюу түүнээс дээш тогтмол шинжтэй өөрчлөлт оруулах буюу нэмэгдэл нислэгийн хүсэлтийг Цагийн хуваарийн зөвлөлд хүргүүлнэ.” гэж, 5.1.2 дахь заалтад “Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээнд орсон хуваарьт нислэг цаг агаарын болон агаарын хөлгийн техникийн шалтгаанаар цуцалсан талаарх мэдээг нислэг эхлэхээс 1 цагаас багагүй хугацааны өмнө ирүүлнэ.” гэснийг “Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээнд орсон хуваарьт нислэг цуцалсан талаарх мэдээг нислэг эхлэхээс 1 цагаас багагүй хугацааны өмнө ирүүлнэ.” гэж, 5.2.1 дэх заалтад “Хавсралт 3” гэснийг “Хавсралт 2” гэж, 9.1 дэх заалтад “Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх тохиолдолд нислэгийн төлөвлөгөөг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагад тухайн нислэг эхлэхээс 30 минутаас багагүй хугацааны өмнө ирүүлнэ.” гэснийг “Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх тохиолдолд нислэгийн төлөвлөгөөг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагад Иргэний нисэхийн багц дүрмийн дагуу ирүүлнэ.” гэж, 3.1.12 дахь заалтад “Энэхүү журамд заасан баримт бичгийн бүрдэл дутуу, зөрчилтэй, хугацаа дууссан, хүчингүй болсон тохиолдолд нислэгийн зөвшөөрөл олгохоос татгалзана.” гэснийг “Баримт бичгийн бүрдэл дутуу, зөрчилтэй, хугацаа дууссан, хүчингүй болсон, агаарын зайн болон нисэх буудлын багтаамж, нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсээс шалтгаалан нислэгийн зөвшөөрөл олгохоос татгалзаж болно.” гэж тус тус өөрчилсүгэй.

2.Энэ журмын 3.1.6-д “Нислэгийн хүсэлт гаргагчаас ирүүлсэн олон улсын хуваарьт бус хөөрөлт, буултын нислэгийн хүсэлт, түүнд холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, агаарын зайн болон нисэх буудлын багтаамж, газрын үйлчилгээний мэдээлэл зэрэг бусад хүчин зүйлүүдийг харгалзан нислэгийн зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.” гэх заалт, 3.1.7-д “Зөвшөөрөл олгох тохиолдолд агаарын зайн болон нисэх буудлын багтаамж, газрын үйлчилгээний мэдээлэл зэрэг бусад хүчин зүйлүүдийг харгалзан нислэгийн өдөр, цагийг өөрчлүүлж болно.” гэх заалт, 5.3.2-т “Нислэгийн хүсэлт гаргагч нь батлагдсан хуваарьт нислэгийн төлөвлөлтөд 2-4 удаагийн өөрчлөлт оруулах болон нэмэгдэл нислэгийн хүсэлтийг нислэг эхлэхээс ажлын 5 хоногийн өмнө Хавсралт 2-т заасан маягтын дагуу ирүүлнэ.” тус тус нэмсүгэй.

3.Журмыг мөрдөж ажиллахыг Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба /Т.Батбаяр/-нд, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төв /Н.Батсайхан/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газар (Ч.Одгэрэл)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН